



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/447

Мандалговь

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
үйл ажиллагааг дэмжих тухай

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, 34 дүгээр зүйлийн 34.1, 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулж буй урлаг, спортын арга хэмжээний зардалд 2,000.000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 2,000.000 (хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

